



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 017

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан нэр бүхий 19 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай **82,835,000.00** /наян хоёр сая найман зуун гучин таван мянга/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.



Б.БАТЦЭЦЭГ

101220141

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д 2022.12.28-нд гэнэтийн байдлаар нас барсан Далантайн Болдбаатарын шарилыг чандарлаж эх нутагт нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
2	2022.10.22-нд Франц улсад эмчилгээ хийлгэж байгаад нас барсан Авирмэдийн Мөнхсүхийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
3	БНСУ-д 2022.10.02-нд өндөр халуурч эмнэлгийн сэхээн амьдруулах тасагт эмчлүүлж байгаад нас барсан Эрхэмбаатарын Тэнүүний эмчилгээ болон шарилыг чандарлуулж оршуулахад гарсан зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
4	Истанбулын Истиние их сургуулийн “Лив” эмнэлэгт элэг шилжүүлэн суулгах хагалгаа хийлгэж хагалгааны хүндрэлээс болж нас барсан Энхмөнхийн Санчирбаатар /8 сартай/-ын оршуулгын зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
5	БНСУ-д 2022.12.22-нд гэнэтийн байдлаар нас барсан Цогтсайханы Батбаярын шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
6	БНТУ-ын Анталья хотод 2023.01.01-нд өндрөөс унаж нас барсан Цэгмидийн Амархүүгийн шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
7	БНСУ-д 2023.01.01-нд бусдын гарт амь насаа алдсан Нямсүрэнгийн Отгонбилэгийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
8	Толгойдоо бэртэл авсны улмаас БНСУ-ын Сөүл ВИП асрамжийн эмнэлэгт 2023.01.22-ны өдөр нас барсан Ганхуягийн Энхсайханы шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
9	БНСУ-ын Санжу хотод 2022.12.09-нд барилгын нурангид дарагдан нас барсан Батболдын Тамирын шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
10	2023.01.12-нд АНУ-ын Сиатл хотод гэнэтийн тохиолдлоор нас барсан Ламжавын Сийлэгмаагийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	3,500,000 төгрөг
11	Япон Улсын Окинавад суралцаж байх үедээ 2023 оны 02 дугаар сарын 10-нд золгүй явдлаар нас барсан Цэрэнхуягийн Лхагва-Эрдэнэнийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5,500,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		

12	БНСУ-д 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр зам тээврийн осолд орж нүүр, хавирга, элэг, хөлөндөө бэртэл авч, эмчилгээ хийлгэсэн Дамбасүрэнгийн Гэрэлсайханд үзүүлэх санхүүгийн дэмжлэг,	3,000,000 төгрөг
13	БНФУ-ын Коон хотод оршин сууж байсан, орон гэргүй, сэтгэцийн өвчтэй иргэн Гэндэнсүрэнгийн Батбаярыг эх оронд нь буцаах зардал,	4,500,000 төгрөг
14	ОХУ-ын Москва хотын Санхүүгийн их сургуульд сурдаг оюутан Бямбаагийн Энхжаргал нь метронд ухаан алдаж унасны улмаас хүнд бэртэл авч Москва хотын Боткины нэрэмжит эмнэлэгт эмчилгээ хийлгэхэд дэмжлэг үзүүлэх,	5,000,000 төгрөг
4.3.3. хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэнийг эх оронд нь буцаах; гэснийг үндэслэн;		
15	Беларусь Улсад гадаад иргэн оршин суух журмыг зөрчсөн гэх үндэслэлээр өнгөрсөн 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдрөөс Беларусь Улсын Брест хотын Ленин дүүргийн Дотоод хэргийн хэлтэст саатуулсан Пүрэвийн Өнөрбатын Монгол руу буцах зардал,	1,500,000 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
16	БНСУ-ын Кёнги мужийн Гуанжү хотод ажлын байран дээрээ бусдын хүчирхийлэлд өртсөн Тогтохын Уранбилэгийн өмгөөллийн зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
17	БНСУ-ын Кёнги мужийн Гуанжү хотод ажлын байран дээрээ бусдын хүчирхийлэлд өртсөн Тэгшээбаатарын Пүрэвсүрэнгийн өмгөөллийн зардлын тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
“Дүрмийн 4.3.2. заалт буюу хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, алан хядах ажиллагаа, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах” гэснийг үндэслэн;		
18	Туркийн өмнөд хэсэгт хүчтэй газар хөдлөлт болж ЭСЯ-наас гамшигт нэрвэгдсэн бүсүүдэд амьдарч байсан 8 монгол иргэнд нийт 6732 турк лира буюу 358.09 ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлэх,	1,280,000 төгрөг
4.3.5. энэхүү дүрмийн 4.1.3-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
19	Хулгайн хэргээр БНХАУ-ын Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу 10 хоногийн хугацаанд баривчлагдан шалгагдаж байгаа иргэн Батсүхийн Гансүхийн буцах үнэмлэхний төлбөр,	55,000 төгрөг
Дүн		82,835,000.00 төгрөг

Нийт дүн 82,835,000.00 /наян хоёр сая найман зуун гучин таван мянга/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 9/51

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 2 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан нэр бүхий 9 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон Монгол Улсаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод суугаа Консулын газарт шаардлагатай нийт **50,000,000.00** /тавин сая/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

10123019

**"ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН"-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 2 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
"Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах" гэсэн заалтыг үндэслэн;		
1	БНСУ-д 2023.04.03-нд шатнаас унаж тархиндаа хүнд гэмтэл авсны улмаас эмчилгээ даалгүй 2023.04.07-нд нас барсан иргэн С.Төгөлдөрийн шарилыг чандарлаж эх нутагт нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
2	Япон Улсын Токио хотод 2023.03.21-нд нас барсан иргэн Т.Төгөлдөрийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
3	Ирланд улсад сурч ажиллаж байгаад 2023.01.24-нд өвчний улмаас нас барсан иргэн Б.Түмэнжаргалын шарилыг чандарлуулж оршуулахад гарсан зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
4	БНСУ-ын Пусан хотын эмнэлэгт 2023 оны 04 дүгээр сарын 05-нд уушигны сүрье, бодисын солилцооны ацидоз өвчний улмаас нас барсан иргэн О.Цэнд-Аюушийн шарилыг чандарлуулж оршуулахад гарсан зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
5	Иргэн Б.Алтаншагай нь Тайваний Шинжлэх ухаан, техникийн их сургуульд суралцаж байсан бөгөөд хүнд өвчний улмаас 2023.05.06-нд нас барсан. Талийгаачийн эмчилгээний зардлын тодорхой хэсэг,	6,000,000 төгрөг
6	БНСУ-ын Чэжү хотод хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон иргэн Г.Солонгийн хууль ёсны эрх ашгийг хамгаалуулахаар БНСУ-ын "Энержи" хууль зүйн фирмийн өмгөөлөгчид төлөх төлбөрийн тодорхой хэсэг,	5,000,000 төгрөг
4.3.5. энэхүү дүрмийн 4.1.3-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
7	2023 оны 1 дүгээр сарын 8-ны өдрөөс Замын-Үүд, Эрээний хилийн боомтоор зорчигчийн хөдөлгөөн сэргэсэнтэй холбогдуулан тус боомтоор өдөрт 3 мянга гаруй иргэн зорчиж иргэд гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох, нас барах тохиолдуулд эрс нэмэгдэн иргэдээс санхүүгийн болон бусад тусламж хүсэх хандлага нэмэгдэж байгааг харгалзан,	10,000,000 төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		
8	БНЛАУ-д гэмт хэргийн хохирогч болсон иргэн И.Алтжин, Э.Номин-Эрдэнэ, Б.Болортуяа нарыг Монгол Улсаас БНЛАУ-д суугаа ЭСЯ-ны байранд байрлуулах, хооллох, муж хооронд тээвэрлэхтэй холбоотой гарсан зардал,	5,000,000 төгрөг
Дүн		50,000,000.00 төгрөг

Нийт дүн 50,000,000.00 /тавин сая/ төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, “Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2023 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан нэр бүхий 12 иргэнтэй холбоотой тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон БНТУ-д ял эдэлж буй 13 монгол иргэнд дэмжлэг үзүүлэх зэрэг нийт 60,903,000.00 /жаран сая есөн зуун гурван мянган/ төгрөгийг “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

2023-09-21

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 3 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	Иргэн Н.Мандахбаяр БНТУ-д ажиллаж байхдаа тархины баруун талдаа цус харваж, сэхээн амьдруулах тасагт 7 сарын турш хэвтэж эмчлүүлсэн. 2023.6.27-нд нас барсан. Шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6 сая төгрөг
2	Иргэн Ж.Хүдэр 2023.6.22-нд Словак улсын Вишни хотод нас барсан. Ж.Хүдэрийн шарилыг чандарлуулж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	2 сая 100 мянган төгрөг
3	Иргэн Ц.Баяржаргал нь АНУ-ын Лос Анжелес хотод ажиллаж амьдарч байгаад 2023.03.23-нд гэнэтийн байдлаар нас барсан. Талийгаачийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6 сая төгрөг
4	Иргэн А.Бат-Эрдэнэ БНТУ-д эмчилгээ хийлгэж байгаад өвчнөө даалгүй 2023.6.16-ны өдөр нас барсан. Талийгаачийн шарилыг нь эх орондоо авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6 сая төгрөг
5	Иргэн Т.Цэнд-Эрдэнэ нь 2023 6.19-нд БНСУ-ын Гүнсан хотын Чилсон 5 гил 148, 301 тоотод нас барсан байдалтай олдсон. Талийгаачийн шарилыг нь эх орондоо авч ирэх зардлын тодорхой хэсэг,	6 сая төгрөг
6	Иргэн Б.Лхагвасүрэн нь зүрхний инфаркт өвчний оноштойгоор Турк Улсад 2023 оны 7 дугаар сарын 29-ний өдөр нас барсан. Талийгаачийн шарилыг нь эх орондоо авч ирэх зардлын тодорхой хэсэг,	5 сая төгрөг
7	Иргэн Н.Батбаяр нь БНСУ-н онгоцны буудал дээр эрэгтэйчүүдийн ариун цэврийн өрөөнд нас барсан. Талийгаачийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардал болон бусад гарсан зардлуудыг тодорхой хэсэг	6 сая төгрөг
8	Иргэн Д.Энэбиш нь АНУ-ын Чикаго хотод эмчилгээ хийлгэж байгаад 2022 оны 8 дугаар сарын 26-нд гэнэт нас барсан. Талийгаачийн шарилыг нь эх орондоо авч ирсэн зардлын тодорхой хэсэг,	6 сая төгрөг
9	Иргэн Ч.Бат-Ерөөлт БНСУ-ын Согчу далайн эрэгт 2023 оны 7 дугаар сарын 2-ны өдөр усанд живж зуурдаар нас барсан. Талийгаачийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирсэн зардлын тодорхой хэсэг,	5 сая төгрөг
10	Иргэн Д.Батчулуун нь БНСУ-д 2023 оны 8 дугаар сарын 2-ны өдөр зуурдаар нас барсан. Талийгаачийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирсэн зардлын тодорхой хэсэг	5 сая төгрөг
11	Иргэн Д.Лхамжав 2023 оны 6 дугаар сарын 18-нд өвчний улмаас Швейцарь Улсад нас барсан. Талийгаачийн шарилыг чандарлаж эх оронд нь авч ирэх зардалын тодорхой хэсэг	3 сая 500 мянган
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
12	Анкара дахь ЭСЯ-ны тойрогт тойрогт ял эдэлж байгаа Монгол Улсын долоон иргэн, Истанбул дахь ЭСЯ-ны тойрогт зургаан иргэн, нийт 13 иргэн 1-22 жилийн ял авсан бөгөөд одоог хүртэл ямар нэгэн дэмжлэг туслалцаа аваагүй тул нэг удаагийн мөнгөн дэмжлэг туслалцаа үзүүлэх саналыг ирүүлсэн. Нэг иргэнд 50 ам.долларын дэмжлэг үзүүлэх саналыг Анкара дахь ЭСЯ-наас ирүүлсэн. Нийт 650 ам.доллар	2 сая 300 мянган төгрөг
4.3.6. хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль хяналтын байгууллагаар хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;		

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
13	Иргэн Ц.Бишрэлт нь ОХУ-д найз залуудаа удаа дараа зодуулж, хүчирхийлүүлсэн. Гэр бүлийн хүчирхийлэл цаашид дахин гарч болзошгүй тул Монгол Улс руу буцахад дэмжлэг хүсч Москва дахь ЭСЯ-нд Монгол руу буцахад дэмжлэг үзүүлэх тухай өргөдөл гаргасан. Тээврийн зардал, Москва дахь ЭСЯ-ны төсвөөс нийт 61828 рубль зарцуулсан.	2 сая 003,000 мянган төгрөг
Дүн		60 сая 903.000 төгрөг

Нийт дүн: 60 сая 903 000 төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад нэр дурдсан 3 иргэнд дэмжлэг үзүүлэх, БНХАУ-ны ӨМӨЗО-нд ял эдэлж буй 44 иргэнийг эргэх, БНХАУ-д ял эдэлж байгаад эх орондоо шилжин ирсэн 11 иргэний буцах үнэмлэхний төлбөр, хүний наймааны хохирогч болсон 6 иргэнийг БНАЛаосАУ-аас эх оронд нь авчирсан замын зардал, БНЧехУ-д хууль бусаар оршин сууж байгаад саатуулагдсан 2 иргэнд олгосон буцах үнэмлэхний төлбөр, Газын зурваст үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан эх орондоо буцах хүсэлт гаргасан 17 иргэнийг эх оронд нь авчирсан зардал нийт 116,743,495.00 /нэг зуун арван зургаан сая долоон зуун дөчин гурван мянга дөрвөн зуун ерөн таван / төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101230340

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	Иргэн Ү.Отгонбаяр нь 2023.10.2-нд БНСУ-д зуурдаар таалал төгссөн. Шарилыг эх оронд нь авч ирэхэд иргэдэд туслах сангаас туслахыг хүссэн. Шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг. Нийт зардал 18.980.000 төгрөг болсон. Энэ зардлын 50% ИТС-аас гаргуулахыг хүссэн. /9.490.000 төгрөг/.	6,000,000 төгрөг ✓
2	Иргэн С.Эрдэнэчулуун 2023.9.8 -нд БНСУ нас барсан. Амьжиргааны түвшин дунджаас доогуур орлоготой өрх тул шарилыг чандарлуулан эх оронд нь авч ирэхэд иргэдэд туслах сангаас дэмжлэг хүссэн. Шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг. Талийгаачийн шарил чандарлахад 10 сая төгрөгийн дэмжлэг хүссэн.	6,000,000 төгрөг
		12,000,000
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
3	Хөх хот дахь ЕКГын хариуцсан тойргот нийт Монгол Улсын 44 иргэн хорих ял эдэлж байгаа бөгөөд Эрэгтэйчүүдийн хорих ангид олон жилийн хорих ялтай 34 иргэн, Эмэгтэйчүүдийн хорих ангид 10 иргэн. Ял эдэлж буй иргэдийг эргэхэд (иргэдэд туслах сангийн дүрмийн 4.3.5, 4.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн) /хүн бүрт 2000 юань/, нийт 88,000.00 юань иргэдэд туслах сангаас туслалцаа үзүүлэх саналыг Хөх хот ЕКГ-аас ирүүлсэн.	Нэг хүнд 500 юань олгох саналтай. Ял эдэлж буй эдгээр 44 хүнд нийт 22000 юань буюу 10,445,600 төгрөг.
		10,445,000
4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
	Ялтан солилцох хэлэлцээрт хамрагдсан 11 иргэний буцах үнэмлэхний төлбөрт 1245 юань	11 ширхэг буцах үнэмлэхний 1245 юань буюу 591,126 төгрөг
4	Хүний наймааны хохирогч болсон Монгол Улсын 6 иргэнийг БНАЛАУ-аас эх оронд нь буцаасан зардал 1479 ам доллар.	5,120,298 төгрөг
5	Чех Улсад хууль бусаар оршин сууж байсны улмаас саатуулагдсан Монгол Улсын 2 иргэнд олгосон буцах үнэмлэхний төлбөр 770 чех крон.	114,000 төгрөг
		5,825,424
4.3.2. хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;		
6	Газын зурваст үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан эх орондоо буцах хүсэлт гаргасан 17 иргэнийг эх оронд нь авчирсан зардал. Онгоцны тийзний үнэ нийт 87.530.000 төгрөг	87.530.000 төгрөг
7	Иргэн. А.Болормаа нь БНСУ-д 2021 оны 6 дугаар сард нас барсан дүүгийнхээ хэргийн асуудлаар тус улсад очоод сэтгэл санааны хямралд орж, биеийн байдал муудан, нутаг буцах замын зардалгүй болсон. ЭСЯ-наас зардлыг гаргасан. Нийт 361.000 вон	942,471 төгрөг ✓
		116,743,495 төгрөг
Дүн		

Нийт дүн: 116,743,495 төгрөг



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Сангийн дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2018 оны 179 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйл болон Сангийн зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын хавсралтад дурдсан 3 иргэнд дэмжлэг үзүүлэх, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны тойрогт ял эдэлж байгаа болон саатуулагдсан иргэдийг /40 иргэн/, Япон Улсад хорих ял эдэлж буй Монгол Улсын 4 иргэнийг эргэх зардал, Чех улсад ял эдэлж байгаад тус улсаас албадан буцаж буй Монгол Улсын 2 иргэн, Ческа Скалица хотод ажиллаж байгаад ажлаасаа халагдан нутаг буцах төлбөрийн чадваргүй болж Чехийн нутаг буцах хөтөлбөрөөр Монгол буцсан 1 иргэнд олгосон буцах үнэмлэхний төлбөр, Эрээн КГ-аас 3 иргэнд олгосон буцах үнэмлэхний төлбөр зэрэгт нийт **26,025, 000 төгрөгийг** /хорин зургаан сая хорин таван мянган/ төгрөгийг "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас гаргахыг Сангийн зөвлөлийн гишүүн, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбатад зөвшөөрсүгэй.

2. Сангаас гаргах хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Сангийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Консулын газрын захирал Б.Болд, Сангийн зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Ч.Ганбат нарт даалгасугай.

САЙД



Б.БАТЦЭЦЭГ

101230378

**“ХИЛИЙН ЧАНАДАД БАЙГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДЭД ТУСЛАХ САН”-ГИЙН
ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ 5 ДУГААР ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭСЭН ТУСЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хаана, хэнд олгох	Олгох тусламжийн хэмжээ төгрөгөөр
“Дүрмийн 4.3.1. буюу хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарилыг эх оронд нь буцаах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах” гэсэн заалтыг үндэслэн;		
1	Иргэн Х.Баясгалан 2023.10.15 -нд БНСУ өвчний улмаас нас барсан. Амьжиргааны түвшин дунджаас доогуур орлоготой өрх тул шарилыг чандарлуулан эх оронд нь авчрахад иргэдэд туслах сангаас туслахыг хүссэн. Шарилыг эх оронд нь авч ирэх зардлын тодорхой хэсэг	6,000,000
3	Иргэн Э.Наранцогт 2023 оны 5 дугаар сарын 16-нд БНСУ-д нас барсан. Амьжиргааны түвшин дунджаас доогуур орлоготой өрх. Шарилыг эх оронд нь авч ирсэн. Иргэдэд туслах сангаас туслахыг хүссэн.	6,000,000
		12,000,000
4.3.7. хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;		
1	Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны тойрогт ял эдэлж байгаа болон саатуулагдсан иргэдийг /40 иргэн/ эргэж уулзах, зарим хэрэглээнд нь зориулж тэтгэмж өгөх саналыг Бээжин дэх ЭСЯ-ны Консулын хэлтсээс ирүүлсэн. Тухайн иргэдэд тулгардаг эрүүл мэндийн үзлэгт хамруулах зэрэг асуудлыг газар дээр нь шийдвэрлэнэ. ИТС-ын 16000 юанийн зардлыг хүссэн.	16000 юань буюу 7.760.000
2	Япон Улсад хорих ял эдэлж буй Монгол Улсын 4 иргэнийг эргэх саналыг ирүүлсэн. 125.000 иен	125.000 иен буюу 2.955.000
		10,715,000
4.2. Сангийн хөрөнгөөс хилийн чанадад байгаа Монгол Улсын төлбөрийн чадваргүй иргэнд тусламж, дэмжлэг үзүүлэх...;		
1	Иргэн Б.Хүрэлхуяг нь БНТУ-д амьдарч байхдаа тархинд нь цус харвасны улмаас хагалгаанд орж, улмаар нутаг буцах зардлыг ИТС-гаас гаргах хүсэлт гаргасан	3,000,000
		3,000,000
4.3.5. энэхүү дүрмийн 4.3.1-4.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;		
1	Эрээн КГ-аас ирүүлсэн саналын дагуу 1 иргэнд, төлбөрийн чадваргүй болсон 2 иргэнд тус тус 3 буцах үнэмлэх үнэ төлбөргүй олгосон тул 45 ам.долларыг хүссэн	45 ам.доллар буюу 155.000
2	Чех Улсын Гадаад Иргэдийн Асуудал Хариуцсан Цагдаагийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Чех улсад ял эдэлж байгаад тус улсын нутаг дэвсгэрийг албадан орхиж буй Монгол улсын 2 иргэн, Ческа Скалица хотод ажиллаж байгаад ажлаасаа халагдан нутаг буцах төлбөрийн чадваргүй болж Чехийн нутаг буцах хөтөлбөрөөр Монгол буцсан 1 иргэнд буцах үнэмлэх олгосон зардал болох 45 ам.доллар	45 ам.доллар буюу 155.000
		310,000
Дүн		26,025,000